



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 27 дугаар зүйлийн 27.3.7 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад ажиллуулах нийгмийн даатгалын төлөөлөгчийн тоог баталж, тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ажлын хөлс олгож ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т даалгасугай.

3. Нийгмийн даатгалын төлөөлөгчтэй байгуулах хөлсөөр ажиллах гэрээний жишиг загварыг баталж, мөрдөн ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.

ДАРГА  С ЧИНЗОРИГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, ажилтан, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийг ажил олгогчид, иргэд, даатгуулагчдад сурталчлан таниулах, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар судалгаа, үнэлгээ хийх ажилд дэмжлэг үзүүлэх, шимтгэлийн өр авлагыг барагдуулах зорилгоор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэх)-тэй байгуулсан гэрээний дагуу нийгмийн даатгалын төлөөлөгчийг ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нийгмийн даатгалын төлөөлөгч сонгох, гэрээ байгуулах

2.1. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоо, ажлын хөлсний хэмжээг ажлын зайлшгүй шаардлага, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн онцлог зэргийг харгалзан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар тогтооно.

2.2. Нийгмийн даатгалын төлөөлөгч нь орон тооны бус байх ба дараах шаардлагыг хангасан иргэдийг сонгон шалгаруулж авна. Үүнд:


2.2.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн мэдлэгтэй;

2.2.2. Ял шийтгэл эдэлж байгаагүй;

2.2.3. Банк, санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;

2.2.4. Тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч, эрх зүйн бүрэн чадамжтай, Монгол Улсын иргэн байх.

2.3. Их, дээд сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засагч, даатгалын чиглэлээр III, IV дамжаанд суралцаж байгаа оюутан, суралцагч, малчин, бичил уурхай эрхлэгч, газар тариаланч зэрэг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нэгтгэсэн нөхөрлөл, холбооны гишүүн, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байсан өндөр насны тэтгэвэр авагч ахмад настан болон бусад шаардлага хангасан иргэд сонгон шалгаруулалтад оролцож болно.



2.4. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 2.2, 2.3-т заасан шалгуурыг хангасан иргэдийг бүртгэн, дараах сэдвийн хүрээнд сургалтад хамруулна. Үүнд:

- 2.4.1. Нийгмийн даатгалын тухай тухай хууль тогтоомж;
- 2.4.2. Эрсдэлийн ойлголт, даатгалын ач холбогдол;
- 2.4.3. Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалтай холбоотой гарсан журам, заавар, аргачлал;
- 2.4.4. “Нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрэм”;
- 2.4.5. Сайн дурын даатгалд хамруулах үйл ажиллагаа;
- 2.4.6. Эрүүл мэндийн даатгалд хамруулах үйл ажиллагаа;
- 2.4.7. Нийгмийн даатгалын болон Хөдөлмөрийн тухай хууль, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага;
- 2.4.8. Статистик, тоо баримтууд;
- 2.4.9. Даатгалын борлуулалт хийх ур чадвар эзэмшүүлэх;
- 2.4.10. Бусад шаардлагатай мэдээлэл.

2.5. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 2.4-т заасан сэдвийн дагуу сургалт явуулсны дараа тухайн нийгмийн даатгалын байгууллагаас томилогдсон ажлын хэсэг шалгалт авч, хамгийн өндөр оноо авч тэнцсэн иргэдтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, нийгмийн даатгалын төлөөлөгч бүрт ажлын түр үнэмлэх олгон, дараах баримт бичгийг бүрдүүлж, хувийн хэрэг нээсэн байна:


- 2.5.1. Иргэний үнэмлэхний хуулбар;
- 2.5.2. Оршин суугаа хороо, багийн Засаг даргын тодорхойлолт;
- 2.5.3. Анкет;
- 2.5.4. Оюутан бол сургуулийн тодорхойлолт, оюутны үнэмлэхний хуулбар;
- 2.5.5. Цагдаагийн ерөнхий газар, аймгийн цагдаагийн хэлтэс, сумын цагдаагийн тасгийн гэмт хэрэгт холбогдолгүй тухай тодорхойлолт;
- 2.5.6. Банк, санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоонд хугацаа хэтэрсэн өргүй тухай лавлагаа;
- 2.5.7. Хөлсөөр ажиллах гэрээ.

Гурав. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

3.1. Нийгмийн даатгалын байгууллага дараах эрхтэй:

- 3.1.1. Нийгмийн даатгалын төлөөлөгчөөр ажиллах иргэдийг бүртгэж, сургалт, шалгалтыг зохион байгуулах;
- 3.1.2. Шалгалтад тэнцсэн иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулах;
- 3.1.3. Хөлсөөр ажиллах гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа, хийж гүйцэтгэх ажил үүрэг, хариуцах ажил, үйлчилгээний чиглэл, тайлан гаргах, тооцоо хийх хугацаа, олгох ажлын хөлс, хүлээх хариуцлагыг тусгах;
- 3.1.4. Нийгмийн даатгалын төлөөлөгч хууль зөрчсөн аливаа үйлдэл гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гэрээг цуцлах;

3.1.5. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн ажлын үр дүнг сар тутам дүгнэж, хангалтгүй ажилласан тохиолдолд энэ журмын 6.2.3-т заасан үндэслэлээр түүнтэй байгуулсан гэрээг цуцалж ажлын түр үнэмлэх, үнэт цаас, маягтыг хураан авах.



3.2. Нийгмийн даатгалын байгууллага дараах үүрэгтэй:

3.2.1. Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын төлөөлөгчид ажлын түр үнэмлэх, холбогдох маягтыг олгох;

3.2.2. Нийгмийн даатгалын төлөөлөгчөөр ажиллах гэрээний хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гаргуулан батлах, үйл ажиллагаанд нь өдөр тутам хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах;

3.2.3. Сурталчилгааны материал, гарын авлагаар хангах;

3.2.4. Хууль, эрх зүйн акт, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүрт сургалт зохион байгуулах;

3.2.5. Нийгмийн даатгалын төлөөлөгчийг гэрээгээр тохирсноос өөр ажилд дайчлан ажиллуулахгүй байх.

Дөрөв. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн эрх, үүрэг

4.1. Нийгмийн даатгалын төлөөлөгч дараах эрхтэй:

4.1.1. Шалгалтад тэнцсэн бол Нийгмийн даатгалын байгууллагатай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллах;

4.1.2. Гэрээгээр хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл, боломжоор хангуулах, ажлын үр дүнд тохирсон ажлын хөлс авах;

4.1.3. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2. Нийгмийн даатгалын төлөөлөгч дараах үүрэгтэй:

4.2.1. Энэ журмын 5 дахь хэсэгт заасан ажил үүргийг хууль тогтоомжийн хүрээнд явуулах;

4.2.2. Үйл ажиллагаандаа хууль дээдлэх, ажил олгогч, иргэд, даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах зарчим баримтлан ажиллах;

4.2.3. Байгууллагаас албан хэрэгцээнд хэрэглэхээр олгосон ажлын түр үнэмлэх, бусад маягт, техник хэрэгслийг хууль бусаар ашиглахгүй байх, үрэгдүүлэх, дутаах тохиолдолд холбогдох хариуцлага хүлээх, гэрээ цуцлагдсан тохиолдолд байгууллагад буцаан өгөх;

4.2.4. Сар бүр ажлаа дүгнүүлэх, ажлын үр дүнгийн тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган Нийгмийн даатгалын байгууллагад танилцуулах.

Тав. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны чиглэл, хориглох зүйл

5.1. Нийгмийн даатгалын төлөөлөгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, , нийгмийн даатгалын шимтгэл төлөхтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;

5.1.2. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил уурхайчдыг нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамруулах, тухайн нутаг дэвсгэрт түр болон байнга оршин суугч айл өрх, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдэд биечлэн зөвлөгөө өгч, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх;

5.1.3. Улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалд хамруулах;

5.1.4. Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний сэтгэл ханамжийн болон сайн дурын нийгмийн даатгалын талаарх судалгааг зохион байгуулахад оролцох, судалгааны боловсруулалт хийх;

5.1.5. Нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаандаа төлөөгүй болон дутуу төлсөн өрийг барагдуулах ажилд нийгмийн даатгалын байцаагчид дэмжлэг үзүүлэх, хамтран барагдуулах;

5.1.6. Нийгмийн даатгалын байгууллагаас зохион байгуулах цаг үеийн ажилд оролцох.

5.2. Нийгмийн даатгалын байгууллага нь гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, тэднийг нийгмийн даатгалд сайн дураар хамруулах зорилгоор Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөгчтэй хамтран ажиллаж болно.

5.3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар ажлын зайлшгүй шаардлагаар мэргэжлийн ур чадвар, туршлагыг харгалзан нийгмийн даатгалын төлөөлөгчийг зөвлөхөөр ажиллуулж болно.

5.4. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

5.4.1. Ажил олгогч, даатгуулагчийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

5.4.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн мөнгийг бэлнээр авах;

5.4.3. Гэрээгээр тохирсноос өөр үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэх;

5.4.4. Төрийн захиргааны байгууллагад давхар хөдөлмөр эрхлэх;

5.4.5. Хууль бус бусад үйлдэл гаргах.

Зургаа. Ажлын хөлс, гэрээ цуцлах

6.1. Нийгмийн даатгалын төлөөлөгчид олгох ажлын хөлсийг нийгмийн даатгалын төлөөлөгчийн нийгмийн даатгалд шинээр хамруулсан даатгуулагч, аж ахуй нэгжийн тоо, оруулсан шимтгэлийн орлого болон барагдуулсан авлагын хэмжээ, ажлын гүйцэтгэлийг нь харгалзан гэрээгээр тохирсон хугацаанд сар бүр олгоно.

6.2. Нийгмийн даатгалын төлөөлөгчтэй байгуулсан гэрээг дараах тохиолдолд цуцална:



6.2.1. Нийгмийн даатгалын төлөөлөгч хөлсөөр ажиллах гэрээгээ цуцлах талаар хүсэлт гаргасан;

6.2.2. Хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд захиргааны санаачилгаар;

6.2.3. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлаа хангалтгүй биелүүлсэн;

6.2.4. Нас барсан;

6.2.5. Төрийн албанд ажиллаж эхэлсэн;

6.2.6. Гэм буруутайг шүүх тогтоосон;

6.2.7. Гадаад улсад явсан;

6.2.8. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Нийгмийн даатгалын байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч нь нийгмийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

7.2. Нийгмийн даатгалын тухай болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, нийгмийн даатгалын байгууллагын нэр болон нийгмийн даатгалын байгууллагаас олгосон ажлын түр үнэмлэхийг ашиглаж хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд зөрчлийг бүрэн барагдуулж, нийгмийн даатгалын төлөөлөгчтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээг цуцална.

7.3. Нийгмийн даатгалын төлөөлөгч шимтгэлийн орлогыг бэлнээр авч хувийн зорилгодоо ашиглах, авилга хээл хахууль авах, мэдээллийн нууц задруулах, эрхээ хэтрүүлэх зэргээр үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасан захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---